



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 12 он 01
сарын 05 өдөр

Дугаар 35-1/06

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Тогтоолын төсөл өргөн
мэдүүлэх тухай

“Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000021405089



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20... он... дугаар
сарын...-ны өдөр

Дугаар.../3087

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

“Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 9/ хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000021517284

7



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2021.12.23 № 5-2/7052

танай 2021.12.16 ны № ХЭГ/2985-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ ТАНАА

Таны 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн ХЭГ/2985 тоот албан бичгээр ирүүлсэн “Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг олгож байна.

Б.ЖАВХЛАН

9764003231



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn


2021. 12. 21 № 1/5454
танай 2021. 12. 16 -ны № 21/2985-Т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Ц.НЯМДОРЖ ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар
зүйлийн 20.8-д заасны дагуу “Тогтоолын
хавсралтыг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын
Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд
өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР




6

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 63 дугаар тэмдэглэлд:

“ХII.ХЭЛЭЛЦСЭН нь: “Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн
мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА
Ц.НЯМДОРЖ

БАТЛАВ.
САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД
Х.НЯМБААТАР

**“ТОГТООЛЫН ХАВСРАЛТЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.” гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10-т “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” гэж “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн хавсралт баримт бичгийг” гэж, мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2-т “энэ хуулийн ...4.1.10...-т заасан баримт бичгийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасныг тус тус баримтлан Улсын Их Хурал батлахаар” заасан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-т “энэ хуульд өөрөөр заагаагүй бол урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт гадаад, дотоод орчны нөлөөлөл, хүчин зүйлээс шалтгаалан улсын эдийн засаг, нийгэм, төсөв, санхүүгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно” гэж заасан.

1.2.Практик шаардлага

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас үүдэлтэй дэлхий дахинд нийгэм, эдийн засгийн хүндрэлүүд үүсч байгаатай адил Монгол Улсын эдийн засаг, нийгэм, төсөв, санхүүгийн нөхцөл байдал өөрчлөгдөөд байна.

Монгол Улсын эдийн засаг (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2018 онд 7.7 хувь, 2019 онд 5.6 хувийн өсөлттэй байсан бол Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөлөөгөөр 2020 онд 4.6 хувиар буураад байна.

10

Монгол Улсын экспортын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 0.6 хувиар, импорт 13.5 хувиар тус тус буурсан бол хөдөлмөр эрхлэгчдийн 47 хувь нь цалин буурах, ажлын байраа алдах, түр зогсолт хийх зэрэг сөрөг үр дагавартай нүүр тулсан байна.

Харин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 16 хувь нь орлогоо бүрэн алдсан бол дөрвөн аж ахуйн нэгж тутмын гурвынх нь орлого буурсан байна.

Экспортын орлогын бууралт нь дотоодын аж ахуйн нэгжүүдийн орлого буурахад нөлөөлж, улмаар хөдөлмөрийн зах зээлээр дамжин өрхийн орлогод сөргөөр нөлөөлж байна.

Төсвийн орлого болон валютын нөөцийг голчлон бүрдүүлдэг уул уурхайн голлох бүтээгдэхүүний үнэ болон эрэлт буурсан нь уул уурхайн салбар огцом агшихад нөлөөлөхийн зэрэгцээ тээвэр, агуулах болон боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа саарсан, үйлдвэрлэлийн түүхий эд, орцын нийлүүлэлт доголдсон, иргэдийн хүлээлт болгоомжлолоос үүдэлтэй худалдан авалт, эрэлт багассан, Засгийн газар, иргэд, аж ахуйн нэгж болон эдийн засгийг дэмжих зорилгоор төсвийн зардлаа нэмэгдүүлснээр төсвийн алдагдал өсөх, дотоод болон гадаад өр нэмэгдэх зэрэг томоохон эрсдэл байсаар байгаа нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг удаашруулахад хүргэж байна.

Эдийн засгийн энэхүү нөхцөл байдалтай холбогдуулан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн, шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний болон техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт бүхий Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т /цаашид “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр” гэх/ туссан төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, санхүүжилт саатах зэрэг хүндрэлүүд үүсээд байна.

Иймд хүчин төгөлдөр үйлчилж байгаа “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт болон санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт, мөн гэрээ сунгагдаж санхүүжилт нэмэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалтад нэмэлт оруулах, мөн жагсаалтаас хасалт хийх, бусад төсөл, арга хэмжээний жагсаалт хооронд шилжүүлэх, төсөл, арга хэмжээний байршил, төсөвт өртөг, санхүүжилтийн эх үүсвэр, хуваарь болон хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүд зэргийг өнөөгийн үүссэн нөхцөл байдалд нийцүүлэн засварлах зэрэг өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Ингэснээр тус хөтөлбөрийн 50-аас дээш хувьд өөрчлөлт орохоор байх тул тогтоолын төслийг Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөлөлтэй уялдуулан, Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Хоёр.Тогтоолын төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөл нь 5 заалттай байх бөгөөд тогтоолын төслийн 1 дэх заалтаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн, шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний болон техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт бүхий Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг шинэчлэн батлах, 2 дахь заалтаар хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тухайн жилийн улсын төсөвт тусгаж байхыг даалгах, 3 дахь заалтаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг үүрэг болгох, 4 дэх заалтаар тогтоол батлагдсантай холбогдуулан хүчингүй болгох эрх зүйн акт, 5 дахь заалтаар тогтоолыг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Тогтоолын төсөл батлагдсанаар хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээ хэрэгжих хууль, эрх зүйн үндэслэл болон нийгэм, эдийн засгийн бодит нөхцөл бүрдэнэ.

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр хэрэгжих бодитой нөхцөл хангагдсанаар эдийн засгийн өсөлтийг хангах стратегийн мега төслүүд хэрэгжиж, хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрүүд тодорхойлогдон, төслийн ашиглалт, үр өгөөж дээшилж, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай уялдсан байдал, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Засгийн газрын тухай, Төсвийн тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцэх бөгөөд тогтоолын төсөл батлагдсантай холбогдуулан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болгоно.

12

**“ТОГТООЛЫН ХАВСРАЛТЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.10, 6.7.1, 9.4.2, Төсвийн тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлийг үндэслэн “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон салбарын хөгжлийн зорилт, төсөл, арга хэмжээтэй уялдуулан, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг боловсруулж, **Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор** баталсан.

Тус хөтөлбөрийн хавсралтаар батлагдсан санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн нийт 49.7 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 150 төсөл арга хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай 18.6 их наяд төгрөгийн санхүүжилт шаардлагатай 88 төсөл арга хэмжээ, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай 98 төсөл арга хэмжээ батлагдсан.

Дэлхий даяар тархаад буй Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын дэгдэлттэй холбоотой 2020 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас онц байдал зарласнаар олон улсын нислэгүүд цуцлагдсан, Монгол Улс дотооддоо хөл хорио тогтоож, зарим салбарын үйл ажиллагааг үе шаттайгаар зогсоох хүртэл арга хэмжээ авснаар улсын эдийн засаг, нийгэм, төсөв, санхүүгийн нөхцөл байдал өөрчлөгдөөд байна.

Цар тахлаас үүдэлтэй хөл хорионы улмаас бодит дотоодын нийт бүтээгдэхүүн 2020 оны гүйцэтгэлээр 4.6 хувиар агшлаа. Эдийн засгийн 4.6 хувийн бууралтад үйлчилгээний салбарын бууралт голлон нөлөөлсөн буюу 3 нэгж хувийг бүрдүүлжээ. Түүнчлэн тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, бөөний болон жижиглэн худалдаа, уул уурхайн олборлолтын салбарууд голлох нөлөөг үзүүлсэн байна. Эдийн засгийн идэвхжил саарч, бизнесийн үйл ажиллагаа хумигдан, бүтээгдэхүүний цэвэр татвар эдийн засгийн өсөлтийг 1.1 хувь нэгжээр бууруулжээ.

Дэлхийн болон бүс нутгийн эдийн засагт Ковид-19 цар тахлын үзүүлж буй сөрөг нөлөөллийн улмаас манай эдийн засгийн гол салбар болох уул уурхай, олборлолтын салбарын бүтээгдэхүүний эрэлт багассан нь нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, газрын тосны экспорт болон олборлолтын хэмжээ эрс буурахад хүрч, Экспорт 2020 онд өмнөх оноос 43.3 (0.6%) сая америк доллароор, импорт 858.6 (13.5%) сая ам.доллароор тус тус буурсан байна.

Түүнчлэн Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2018 онд 27.9 тэрбум төгрөгийн ашигтай гарч байсан бол 2020 онд төсвийн орлого 9.5 их наяд төгрөг, зардал 13.9 их наяд төгрөг болж, төсөв 4.4 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан байна. Татварын ачаалал 2020 онд 22.7 хувь болж, өмнөх оноос 3.2 нэгж хувиар буурлаа. Энэ нь эдийн засгийн үйл ажиллагаа, татварын орлого буурсантай холбоотой байна.

Экспортын орлогын бууралт нь дотоодын аж ахуй нэгжүүдийн орлого буурахад нөлөөлж, улмаар хөдөлмөрийн зах зээлээр дамжин өрхийн орлогод сөргөөр нөлөөлж байна.

13

Эдийн засгийн энэхүү нөхцөл байдалтай холбоотойгоор "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад тусгагдсан төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилт удаашрах, санхүүжилт саатах зэрэг хүндрэлүүд үүссэн тул Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 19.1.2 дахь заалтыг үндэслэн "Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Иймд төсвийн ерөнхийлөн захирагчдаас санал авч, төслийн хэрэгжилтийн явц, бусад холбогдох мэдээлэлд үндэслэн, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөлөл, гадаад өрийн зохист хэмжээнд нийцүүлэн тогтоолын төслийг боловсруулсан.

Энэхүү төсөлд санхүүжилтийн эх үүсвэр бүрэн болон хэсэгчлэн шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалтад нийт 45.4 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 136 төсөл арга хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалтад нийт 31.5 их наяд төгрөгийн санхүүжилт шаардлагатай 135 төсөл арга хэмжээ, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалтад нийт 89 төсөл арга хэмжээг тусгасан.

Тогтоолын төсөлд тусгагдсан төсөл, арга хэмжээ хэрэгжсэнээр 2021-2025 онд нийт 149,226 ажлын байрыг шууд ба шууд бусаар шинээр бий болгож, ажилгүйдэл болон ядуурлын түвшинг бууруулахаар байна.

Монгол Улсын төсвийг их хэмжээгээр тэлж, төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх, улмаар арилжааны өндөр хүүтэй гадаад, дотоод зээллэгээр төсвийн алдагдлыг санхүүжүүлэх нь өрийн дарамтыг нэмэгдүүлэх хүчин зүйл болдог. Хөнгөлөлттэй нөхцөлтэй гадаад зээлийн ашиглалтыг нэмэгдүүлснээр Засгийн газрын өрийн үлдэгдлийн өнөөгийн үнэ цэн буурч, өрийн багцын эргэн төлөлтийн дундаж хугацаа уртсах, жигнэсэн дундаж хүүгийн түвшин буурах зэрэг эерэг нөлөө үзүүлж байгаа боловч цаашдаа Засгийн газрын өрийн үйлчилгээний зардал болон валютын ханшийн эрсдэлийг нэмэгдүүлэх, төсөвт болон төлбөрийн тэнцэлд дарамт учруулах сөрөг нөлөөг үзүүлдэг. Энэ нөхцөлд Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн ашиглалтыг хязгаарлах, Засгийн газрын өрийн багцын гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулах шаардлагатай байна.

---oOo---